

ДОТООД ХЯНАЛТЫН МЭРГЭЖИЛТЭНИЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХЫГ УРЬЖ БАЙНА.

Гүйцэтгэх үндсэн чиг үүрэг:

1. Байгууллагын төлөвлөгөөний биелэлтэд дотоод хяналт шалгалтыг хийх;
2. Эрсдлийн удирдлагыг сайжруулах, ажлын үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр аливаа үйл ажиллагаанд бодит үнэлгээ өгөх, удирдлагыг шийдвэр гаргалтад шаардлагатай үнэн бодит мэдээллээр хангах;
3. Эрүүл мэндийн салбарт болон байгууллагын хэмжээнд мөрдөн ажиллах, нийтээр даган мөрдөх хэм хэмжээг тогтоосон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, удирдлагад дэмжлэг үзүүлэх, байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, сайжруулах;
4. Эрх бүхий хөндлөнгийн байгууллагуудаас хийгдсэн хяналт, шалгалт, үнэлгээний дүн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт хийх;
5. Байгууллагын удирдлагын шийдвэрээр төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж, үр дүнг удирдлагуудад мэдээлэх, санал зөвлөмж боловсруулах;
6. Аливаа хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

Тавигдах шаардлага:

1. Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуулийг бакалавр зэрэгтэй төгссөн эмч, эмнэлгийн мэргэжилтэн байх;
2. Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;
3. Дотоод хяналтын чиглэлээр гадаад, дотоодын урт, богино хугацааны сургалтад хамрагдсан байх, мэргэшсэн байх;
4. Эрүүл мэндийн салбарт 8-аас доошгүй жил ажилласан байх;
5. Дотоод хяналт, аудит, чанарын удирдлагын чиглэлээр 3-аас дээш жил ажилласан туршлагатай байх;
6. Бичиг баримт боловсруулах, дүн шинжилгээ хийх өндөр ур чадвартай байх;
7. Дотоод хяналтын мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад хамрагдсан бол давуу тал болно
8. Багаар ажиллах чадвартай, ёс зүйн зөрчилд холбогдоогүй байх;

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн маягт
- Төгссөн их, дээд сургуулийн дипломын хуулбар
- Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
- Эрдмийн болон мэргэжлийн зэргийн үнэмлэхний хуулбар
- Мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан гэрчилгээний хуулбар
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Ажил хүссэн өргөдөл

Дээрх шаардлагыг бүрэн хангасан материалыг УНТЭ-ийн 5 давхарт өрөө Захиргаа, хүний нөөцийн албанд 2026.05.04-ний өдрийн 15.00 дуустал хугацаанд хүлээн авна.

Сонгон шалгаруулалтыг дараах байдлаар зохион явуулна.Үүнд:

1. Баримт бичгийн шалгаруулалт
2. Ярилцлагын шалгалт

УНТЭ-ийн Захиргаа, хүний нөөцийн алба
2026.04.21

Зөвшөөрсөн: Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Анхтуяа
Хянасан: Захирлын ажлын албаны дарга Ц.Амаржаргал
Хянасан: Захиргаа, хүний нөөцийн албаны дарга Ч.Бямбасүрэн
Боловсруулсан: Захиргаа, хүний нөөцийн албаны менежер О.Лхагвасүрэн